

**“ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО  
БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ АНХНЫ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 05 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Ц. Оюунгэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн билээ.

“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2015 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэлээр ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Арвин, А.Бакей, З.Баянсэлэнгэ, С.Одонтуяа, Д.Сарангэрэл, Л.Энх-Амгалан нарын бүрэлдэхүүнтэй ажлын дэд хэсэгтэйгээр байгуулан ажиллуулсан бөгөөд ажлын дэд хэсэг 3, ажлын хэсэг 1 удаа тус тус хуралдаж, төслийн талаар зарчмын зөрүүтэй 11 саналын томъёоллыг бэлтгэн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд 8 саналыг гишүүдийн олонх дэмжиж, 2 саналыг ажлын хэсэг татан авч, 1 саналыг гишүүд дэмжээгүй болно.

Байнгын хорооны хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа нараас саналын томъёоллын хуудсаар гаргасан төслийн “Нэг. Өнөөгийн байдал, шинэчлэх шаардлага” гэсэн хэсгийг бүхэлд нь хасах санал гишүүдийн олонхын дэмжлэг авч, Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар нарын гишүүд “Малчдын тэтгэврийн нас, тэтгэвэр тогтоох болон тэтгэврийн даатгалын шимтгэл ногдуулах, төлөх харилцааг тусгайлан авч үзэх” гэж төсөлд нэмэх саналаа татаж авав.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг гишүүдэд тараасан тул “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт

бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Д. БАТЦОГТ

**“ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО  
БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН  
ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Нэг. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн санал:**

1.Төслийн 4.2.10 дахь дэд заалтыг “Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн, ахмад настан бүрт суурь тэтгэвэр олгоно. Суурь тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшинтэй уялдуулан Засгийн газраас жил бүр тогтоох бөгөөд суурь тэтгэврийн зардлыг тэтгэврийн даатгалын сангаас болон улсын төсвөөс хариуцан санхүүжүүлнэ.” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц. Оюунгэрэл, Д.Арвин,  
А.Бакей, З.Баянсэлэнгэ, С.Одонтуяа, Д.Сарангэрэл,  
Л.Энх-Амгалан /цаашид “ Ажлын хэсэг” гэх/**

2.Төслийн 4.2.14 дэх дэд заалтыг “2030 оноос эхлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийг хэсэгчлэн хагас хуримтлалын тогтолцоонд, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх;” гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

3.Төслийн 4.2.18 дахь дэд заалтыг “хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг хувийн хэвшлийн тэтгэврийн сан ба уг сан бүхий хувийн хэвшлийн урт хугацааны даатгалын компани эрхлэн гүйцэтгэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо эдгээр сангуудад тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;” гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

4.Төслийн 4.2.22 дахь дэд заалтыг “цэргийн алба хаасны, нийгмийн халамжийн, 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн зардал болон тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг улсын төсвөөс санхүүжүүлэх;” гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

5.Төслийн 4.4.1 дэх дэд заалтыг “хүн амын дундаж насжилттай уялдуулж, тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаарыг өөрчлөх асуудлыг судлах;” гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

6.Төслийн 4.4.2 дахь дэд заалтыг хасах;

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

7.Төслийн 4.4.3 дахь дэд заалтыг “хүүхэд төрүүлж, хуульд заасан нас хүртэлх хугацаанд асарсан эхчүүдийн хүүхдээ асарсан хугацааг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласнаар тооцон даатгалын сангаас олгох жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн хугацааг нэмэгдүүлэх;” гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

8.Төслийн 4.5.1 дэх дэд заалтыг “ахмад настны тэтгэврийн үнэлэмжийг сайжруулах, ирээдүйн ахмад настны тэтгэврийн хувь хэмжээг бууруулахгүй байх үүднээс тэтгэврийн даатгалын санхүүгийн тогтвортой байдлыг хангах эдийн засгийн үр ашигтай болгох бодлого баримтлах;” гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

9.Төслийн “Нэг. Өнөөгийн байдал, шинэчлэх шаардлага” гэсэн хэсгийг бүхэлд нь хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа, А.Тлейхан,  
Ё.Отгонбаяр, Д.Сумьяабазар, Л.Энх-Амгалан**

**Хоёр. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжээгүй санал:**

1.Төслийн 4.6.7 дахь дэд заалтыг “хууль тогтоомжийн биелэлт, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад хяналт тавих, нийгмийн даатгалын үйл ажиллагаа, тайлан мэдээллийг хэлэлцэж, зөвлөмж гаргах үүрэг бүхий Засгийн газар, даатгуулагчийн болон ажил олгогчийн дийлэнх олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагуудаас тэнцүү тоогоор төлөөлсөн зөвлөл байгуулж ажиллуулах.” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО**